



Инфляцын тайлан 2024 | 3-р сар



АГУУЛГА

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ.....	3
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР	4
ТОЙМ.....	5
1. ИНФЛЯЦ	7
1.1. Инфляцын цаашдын төлөв	7
1.2. Инфляцын гүйцэтгэл.....	8
1.3. Төсөөллийн зөрүү.....	9
2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ	10
2.1. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв	10
2.2. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл.....	13
3. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН.....	15
3.1. Хөдөлмөрийн зах зээл.....	15
3.2. Мөнгө, санхүүгийн зах зээл	17
3.2.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд.....	17
3.2.2. Хүү.....	19
3.2.3. Валютын ханш.....	20
3.2.4. Хөрөнгийн зах зээл	21
3.3. Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр.....	24
4. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН	25
4.1. Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл	25
4.2. Экспортын үнийн төлөв.....	26
4.3. Төлбөрийн тэнцэл	28

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ

Төв банкны тухай хуульд **Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах** гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк **инфляцыг дунд хугацаанд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахыг** зорьж байна.

Монголбанкнаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, мөнгө, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшин, түүний хүлээлтийг тогтворжуулахыг зорьдог. Түүнчлэн, 2018 оноос эхлэн макро зохистой бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсвэл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдах зэрэгт чиглэсэн арга хэмжээг мөнгөний бодлогын арга хэрэгслүүдтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна.

Монголбанк мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй харилцах харилцааны нээлттэй байдалд ач холбогдол өгч байна. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад эдийн засаг, санхүүгийн салбар, нийт эрэлт, нийлүүлэлт, ажил эрхлэлт, үнэ, өртгийн хүчин зүйлс зэргийг Инфляцын тайланд танилцуулж, улирал тутам олон нийтэд мэдээлж байна. Төв банкны зорилтод нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулснаар бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанканд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдод ирээдүйн талаар мэдээлэл өгөх, хүлээлтийг удирдах ач холбогдолтой.

Монголбанкны мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүгийн нэгдсэн бодлого, репо санхүүжилт болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Мөнгөний бодлогын шилжих механизм ёсоор банк хоорондын захын хүүгийн өөрчлөлт нь хадгаламж, зээлийн хүү болон бусад хөрөнгийн үнэд нөлөөлснөөр инфляц болон тэдгээрийн ирээдүйн төлөвийн талаарх хүлээлтэд нөлөөлдөг. Ингэхдээ бодлогын хэрэгсэл нь эцсийн зорилт болох эдийн засгийн идэвхжил, инфляцад тодорхой хугацааны хоцролттой нөлөөлдөг.

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү, банкуудын эх үүсвэрийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болж байна. Түүнчлэн бодлогын хүүгийн коридор системтэй уялдуулан мөнгөний бодлогын бусад хэрэгслүүдийн хүү тодорхойлогдож байна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 3-р сарын 14, 15-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад орчны эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 12 хувьд хүргэх;
2. Малчны эргэн төлөлт нь доголдсон зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах боломжийг банкуудад олгох шийдвэрийг тус тус гаргалаа.

Мөнгөний бодлогын 2024 оны 3-р сарын 15-ны өдрийн мэдэгдлийн дэлгэрэнгүйг [эндээс](#) уншина уу.

Инфляцын тайланд орсон тоон өгөгдөл, зураг, хүснэгтийг [дараах](#) линкээр орж татан авах боломжтой.

ТОЙМ

Инфляц буурах хандлага үргэлжлэн энэ онд Төв банкны зорилтын дээд интервал буюу 6-8 хувь орчимд байх суурь төсөөлөлтэй байна. Цаг агаарын хүндрэл, зудын нөхцлөөс шалтгаалан эдийн засгийн өсөлт саарах төсөөлөлтэй байна. Гадаад эдийн засгийн орчны хувьд эрсдэл, тодорхой бус байдал төдийлөн буураагүйн дээр манай улсын худалдааны гол түнш БНХАУ-ын өсөлтийн төлөв саарч, аж үйлдвэрийн салбарын идэвхжил удаашрах зэрэг нь уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт болон үнэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, гадаад орчны төлөв, ирэх жилүүдийн инфляц, эдийн засгийн төсөөллийг харгалзан 2024 оны 3 дугаар сард бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 12 хувьд хүргэх шийдвэрийг гаргалаа. Энэхүү бодлогын шийдвэр гаргахад ашигласан суурь мэдээллийг Инфляцын тайлангаар танилцуулж байна.

Инфляц өмнөх төсөөллөөс бага зэрэг буурахаар байна. Инфляц алгуур буурах хандлага үргэлжилж, энэ оны 2 дугаар сард улсын хэмжээнд 7.0 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 7.2 хувьд хүрлээ. Монголбанкны хатуу мөнгөний хатуу бодлогын нөлөөнөөс гадна худалдааны түнш орнуудын инфляц буурч, төгрөгийн ханш сүүлийн хагас жил гаруйн хугацаанд чангарч, импортын бараа, бүтээгдэхүүний үний өсөлт 2021 оны 6 дугаар сараас хойш тасралтгүй саарч байгаа нь инфляц буурахад голлон нөлөөлж байна. Мөн 2022 оны сүүлийн саруудад өндөр өсөлттэй байсан гурил, гурилан бүтээгдэхүүний үнийн өсөлт саарч 2023 онд тогтворжиж, дотоодын хүнсний инфляцыг сааруулав. Тээврийн зардал, төгрөгийн ханш, гадаад үнэ зэрэг гадаад шалтгаантай үнийн дарамтууд өмнөх төсөөллөөс багасаж, инфляцын төсөөлөл өмнөхөөс буурахаар байна. Ийнхүү энэ онд инфляц Төв банкны зорилтын дээд интервалын орчимд хэлбэлзэж, цаашид алгуур бууран 2026 оны сүүлийн хагаст зорилтын голчид ирэхээр байна. Гэхдээ зудын нөхцөл байдал хүндрэх, цалин өсөх, ногдол ашиг тараах зэрэг дотоод хүчин зүйлсээс шалтгаалан инфляц суурь төсөөлөлд авч үзсэнээс нэмэгдэх эрсдэл байсаар байна.

Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв өмнөхөөс муудлаа. Дотоод эдийн засгийн идэвхжил хүлээлтээс давж, нийт үйлдвэрлэл 2023 оны 4 дүгээр улиралд 7.2 хувиар, 2023 онд 7.0 хувиар өслөө. Нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч, үүнийг дагаад тээврийн салбарын орлого эрчимжсэнээр уул уурхай, тээврийн салбар эдийн засгийн өсөлтийн 4.3 нэгж хувийг дангаар бүрдүүлэв. Өрхийн бодит орлого нэмэгдэж, зээлийн өсөлт сүүлийн хагаст эрчимжсэн нь санхүү, даатгал, зочлох үйлчилгээний салбарын өсөлтийг тэтгэлээ. Эрэлт талаас уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, эцсийн хэрэглээ өсөлтөд гол нөлөөтэй байв.

Гэвч сүүлийн саруудад үүсээд буй цаг агаарын хүндрэл, зудын нөхцөл байдлаас шалтгаалан хөдөө аж ахуйн салбарын уналт үргэлжилж, эдийн засгийн өсөлт энэ онд өмнөх төсөөллөөс муудах хүлээлттэй боллоо. Ирэх онд цаг агаарын нөхцөл олон жилийн дунджийн орчимд хүрч, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сэргэх, Оюу толгойн үйлдвэрлэл эрчимжин уул уурхайн салбарын өсөлтийг тэтгэх, үүний дам нөлөөгөөр нийт эдийн засгийн өсөлт сайжрах хүлээлттэй байна.

Гадаад эдийн засгийн орчинд томоохон өөрчлөлт гараагүй байна. АНУ, ОХУ зэрэг томоохон эдийн засагтай орнуудын эдийн засгийн өсөлт 2023 онд хүлээлтээс давж, дэлхийн

эдийн засгийн өсөлтийн төсөөлөл өмнөхөөс нэмэгдлээ. Харин манай улсын худалдааны гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарах хандлага ирэх онуудад үргэлжилж, өсөлтийн цаашдын төлөв сайнгүй байхаар байна. Ойрын 2 жилд импортын үнэ тогтвортой байх бол экспортын үнэ буурч, худалдааны нөхцөл муудах хүлээлт хэвээр байна. Дэлхийн ихэнх улс орнуудад инфляц үргэлжлэн буурч, бодлогын төлөв сулрах хүлээлт бий болж байна. Хэдийгээр суурь төсөөллөөр дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл нэмэгдсэн хэдий ч олон улсын харилцаанд үүссэн төвөгтэй нөхцөл байдал, түүнээс үүдэлтэй тодорхой бус байдал маш өндөр байна.

Төлбөрийн тэнцэл 2023 оны 4 дүгээр улиралд 666 сая ам.долларын ашигтай гарлаа. Тодруулбал, тайлант улиралд нүүрсний экспорт эрчимжиж, Оюу толгойн зэсийн баяжмалын экспорт хүлээлтээс өндөр гарсны дээр мах, махан бүтээгдэхүүний экспорт сэргэж, урсгал дансны орох урсгалыг дэмжлээ. Санхүүгийн дансны хувьд тайлант улиралд 1 тэрбум ам.долларын ашигтай гарсны дийлэнхийг Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт, хувийн секторын гадаад зээлийн ашиглалт бүрдүүллээ. Ийнхүү төлбөрийн тэнцэл 2023 онд нийт дүнгээр 1.5 тэрбум ам.долларын ашигтай, үүн дотроо урсгал тэнцэл сүүлийн 16 жилд анх удаа ашигтай гарч, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт бага зэрэг саарч, зээлийн өсөлт үргэлжлэн нэмэгдлээ. М2 мөнгөний өсөлт 2023 оны эцэст 26.8 хувьд хүрээд байсан бол энэ оны 1 дүгээр сард 26.1 хувьд хүрч бага зэрэг буурлаа. Үүнд, төлбөрийн тэнцэл 1-р сард 86 сая ам.долларын алдагдалтай гарч, гадаад цэвэр активын өсөлт буурсан нь голлон нөлөөлөв. Банкны системийн зээлийн өсөлт үргэлжлэн нэмэгдэж, 1 дүгээр сард 23.5 хувьд хүрэхэд хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт эрчимжсэн нь гол нөлөөг үзүүлэв. Өнгөрсөн оны эхний 3 улирлын туршид нам түвшинд хадгалагдсан бизнесийн зээлийн өсөлт сүүлийн 2 сард нэмэгдэж, энэ оны 1 дүгээр сард 15.6 хувьд хүрэв. Эдийн засгийн бүх салбарын хувьд зээлийн өсөлт нэмэгдсэн бөгөөд үүн дундаа худалдаа, үйлчилгээ, боловсруулах салбарын зээл голлон өссөн байна. Нийт зээлийн өсөлтийн 60 орчим хувийг хэрэглээний шинжтэй болон ипотекийн зээл бүрдүүлж байна.

Гадаад шалтгаантай үнийн дарамт багасан инфляц энэ онд зорилтын дээд интервалд тогтворжиж, цаашид алгуур буурах хүлээлт хэвээр байна. Гэхдээ инфляцын цаашдын төлөв цаг агаарын нөхцөл байдал, цалин, тэтгэврийн өсөлт, ногдол ашиг тараах зэрэг эрэлт, нийлүүлэлтийн шинжтэй дотоод хүчин зүйлсээс ихээхэн хамаарахаар байна. Цаашид эдийн засгийн сэргэлт, инфляцын өрнөл, нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлс, олон улсад бий болж буй өөрчлөлтүүдтэй уялдуулан инфляцыг дунд хугацаанд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

1. ИНФЛЯЦ

1.1. Инфляцын цаашдын төлөв

Төсөөлөлд ашигласан гол таамаглалт нөхцөлүүд:


- Бодлогын хүүг 2024 оны 1 дүгээр улиралд 12 хувь болгож, 1 нэгж хувиар бууруулах, 2024 оны 2 дугаар улиралд хэвээр хадгалах;
- АИ-92 шатахуун авах гэрээний үнэ өөрчлөгдөхгүй;
- Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ өөрчлөгдөхгүй гэсэн таамаглалт нөхцөл дээр үндэслэн суурь төсөөллийг боловсрууллаа.

Инфляцын төсөөлөл өмнөхөөс бага зэрэг буурлаа. Өвөлжилт хүндэрч зудын нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор хүнсний инфляцын төсөөлөл нэмэгдэж байна. Харин хүнсний бус инфляцын хувьд гадаад инфляц өмнөхөөс буурах, төгрөгийн ам.доллартай харьцах ханш өмнөх төсөөллөөс чанга тогтох, цалин тэтгэврийн өсөлттэй холбоотой эрэлтийн нөлөө хүлээлтээс бага байсан зэргээс шалтгаалан өмнөх төсөөллөөс буурахаар хүлээгдэж байна. Харин хэрэглээний усны төлбөр 1 дүгээр сард жилийн 20 гаруй хувиар өссөн нөлөөгөөр төрийн зохицуулалттай бүтээгдэхүүн, үйлчилгээний инфляц өмнөхөөс нэмэгдэх төлөвтэй байна.

Ирэх онд ханш чанга тогтож, гадаад инфляц саарах зэргээс шалтгаалан нийт инфляц өмнөхөөс буурах хүлээлттэй байна.

Инфляц 2024-2026 оны эцэст харгалзан 8.4 хувь, 7.3 хувь, 6.0 хувь байх төсөөлөлтэй байна.

Зураг 1.1 Инфляцын өмнөх болон одоогийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк

Зудын нөхцөл байдлаас шалтгаалан махны үнэ хаврын саруудад өсөж, цаашид улирлын хандлагаасаа багаар буурах хүлээлттэй байна. Үүнээс шалтгаалан хүнсний инфляцын төсөөллийг ирэх улирлуудад нэмэгдүүлээ. Шатахууны худалдан авах гэрээний үнэ өөрчлөгдөхгүй гэж үзсэнээр шатахууны инфляц оны турш өөрчлөлт багатай байхаар авч үзэв. Гадаад шалтгаантай үнийн дарамт буурсан, төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр өссөн эрэлтийн нөлөө төсөөлснөөс бага гарсан зэргээс шалтгаалан хүнсний бус инфляц цаашид алгуур буурч, нийт инфляц энэ онд Төв банкны зорилтын дээд интервалын орчимд хэлбэлзэхээр байна. Гэхдээ энэ оны 4 дүгээр сараас төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр үргэлжлэн өсөх, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ногдол ашиг тараах зэрэг нь эрэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг нэмэгдүүлж, инфляц төсөөллөөс давах эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.

Ирэх онд цаг агаарын нөхцөл байдал хэвийн болж, махны нийлүүлэлт тогтворжин хүнсний инфляц эргээд буурах, гадаад үнүүд саарах зэргээс шалтгаалан инфляц буурахаар хүлээгдэж байна. Ийнхүү инфляц 2026 оны сүүл хагасаас зорилтын голчид ирж тогтворжихоор байна.

Хүснэгт 1.1 Инфляцын төсөөлөл

	2024.1	2024*	2025*	2026*
		<i>Төсөөлөл</i>		
Инфляц ¹	8.2	8.4 [6.4-10.4] ²	7.3 [4.8-9.9]	6.0 [3.5-8.5]

Эх сурвалж: Монголбанк


Инфляцын төсөөллийг өөрчилж болзошгүй тодорхой бус байдал:

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
Хятад улсын эдийн засгийн өсөлтийн төлөв саарч, аж үйлдвэрийн салбарын идэвхжил удааширнаар уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт болон үнэ буурах эрсдэлтэй. Энэ тохиолдолд экспорт буурснаар гадаад валютын орох урсгал хумигдаж, ханш сулрах дарамт нэмэгдэн, импортын үнээр дамжин инфляц төсөөлснөөс нэмэгдэж болзошгүй.	Дунд	Дунд (Өсгөх)
Төрийн албан хаагчдын цалин, тэтгэврийн хэмжээ энэ оны 4 дүгээр сараас өсөхөөр батлагдсан. Үүнийг дагаад хувийн секторын цалин өсөх дарамт нэмэгдэх, улмаар дундаж цалин хүлээлтээс өндрөөр өсөх тохиолдолд эрэлт, зардлын шалтгаантай инфляц төсөөллөөс давж нэмэгдэх эрсдэлтэй.	Дунд	Өндөр (Өсгөх)
Цалин, тэтгэвэр үргэлжлэн өсөх нөлөөгөөр өрхийн орлого нэмэгдэхтэй зэрэгцээд ЭТТ-н хувьцааны ногдол ашгийг иргэн бүрт бэлэн мөнгө хэлбэрээр тараах зэрэг нь хэрэглээний импортыг эрчимжүүлэх, ханш сулрах дарамтыг нэмэгдүүлэх, цаашлаад инфляц нэмэгдэх эрсдэлийг бий болгоно.	Дунд	Өндөр (Өсгөх)
Цаг агаар, өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүлээгдэж байгаагаас илүү хүндэрч, малын зүй бус хорогдол огцом нэмэгдэх нөхцөлд махны нийлүүлэлт доголдож, үнэ хүлээлтээс өндрөөр өсөж болзошгүй байна.	Дунд	Дунд (Өсгөх)

¹ ХҮИ-ээр хэмжигдэх инфляц, 4 дүгээр улирлын дундаж утга**1.2. Инфляцын гүйцэтгэл**

Монголбанк хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляцыг дунд хугацаанд жилийн 6 хувийн орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулах зорилттой ажиллаж байна.

Инфляц IV улиралд улсын хэмжээнд 8.5 хувь, Улаанбаатар хотод 9.1 хувьд хүрч өмнөх улирлаас 1.3 болон 0.8 нэгж хувиар буурлаа. Үүнд нийт импортын барааны инфляцад үзүүлэх нөлөө 0.6 нэгж хувиар, дотоодын хүнс 0.8 нэгж хувиар буурсан нь голлон нөлөөлөв. Түүнчлэн, мөнгөний хатуу бодлогыг 2023 оны турш хэрэгжүүлсэн нь инфляцын бууралтад нөлөөлж байна.

Зураг 1.2 Инфляц

Эх сурвалж: УСХ

Инфляц 2024 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 7.0 хувь болж үргэлжлэн буурлаа (Зураг 1.2).


Зураг 1.3, 1.4-т үзүүлсэнчлэн инфляцын хөдөлгөөнд голлон нөлөөлж буй бүлгүүдийг дэлгэрүүлж тайлбарлавал:

Импортын бараа, бүтээгдэхүүний инфляц 2021 оны 6-р сараас тасралтгүй саарч, тайлант сард 4.7 хувь болсон байна. Үүнд, хэрэглээний сагсанд томоохон жин эзэлдэг худалдааны түнш орнуудын инфляц

² 30 хувийн магадлалтай итгэх интервал

саарч байгаа нь голлон нөлөөлж байна (Зураг 1.3).

Зураг 1.3 Инфляцын хөдөлгөөнд нөлөөлж байгаа хүчин зүйл³




Эх сурвалж: УСХ, Монголбанк

Дотоодын хүнсний үнийн жилийн өсөлт саарч, 2-р сарын байдлаар 12.8 хувьд хүрчээ. Гэвч өвөлжилт хүндэрч байгаа нь мах, махан бүтээгдэхүүний үнэд нөлөөлж болзошгүй байна.

Үйлчилгээний бүлэг инфляцын 1.3 нэгж хувийг бүрдүүлж, өндөр хэвээр хадгалагдлаа. Хамгийн нөлөө бүхий үйлчилгээний бүлгүүдэд боловсролын үйлчилгээ (инфляцад эзлэх хувь 0.4 нэгж хувь), нийтийн хоолны үйлчилгээ (инфляцад эзлэх хувь 0.4 нэгж хувь) зэрэг багтаж байна.

³ Нийт сагсны 46 хувь нь импортын бараа бүтээгдэхүүнээс бүрддэг. Үүний 44.8 хувийг БНХАУ, 21.7 хувийг ОХУ, 17.1 хувийг Япон, 7.6 хувийг БНСУ бүрдүүлж байна. ОХУ-ын бараа, бүтээгдэхүүний 50 хувийг шатахуун, Японы бараа, бүтээгдэхүүний 97 хувийг автомашин бүрдүүлж байна.

Зураг 1.4 Улаанбаатар хотын жилийн инфляц бүрэлдэхүүнээр⁴



Эх сурвалж: УСХ, Монголбанк

1.3. Төсөөллийн зөрүү

Инфляц 2023 оны IV улиралд төсөөллийн орчимд хүрч буурлаа. Дэлгэрүүлбэл, хүнсний бус бүлэг төсөөллөөс ялимгүй багаар буурахад импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт буурсан нөлөөлсөн бол хүнсний бүлгийн инфляц төсөөллөөс бага зэрэг өндөр гарахад мах, махан бүтээгдэхүүний үнэ төсөөллөөс өндөр өссөн нь нөлөөлөв.

⁴ Үйлчилгээ, төрийн зохицуулалтай үйлчилгээний бүлгийг нэгтгэж “Үйлчилгээ”, хатуу түлш, бусад дотоодын бараа бүлгийг нэгтгэж “Дотоодын бараа”, мах, махнаас бусад дотоодын хүнсний бүлгийг нэгтгэж “Дотоодын хүнс”-ий бүлэг болгов.

2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

2.1. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв

Төсөөлөлд ашигласан гол таамаглалт нөхцөлүүд:

- Бодлогын хүүг 2024 оны 1 дүгээр улиралд 12 хувь болгож, 1 нэгж хувиар бууруулах, 2024 оны 2 дугаар улиралд хэвээр хадгалах;
- Нүүрсний экспортын биет хэмжээ 2024 онд өмнөх төсөөллөөс өөрчлөлтгүй, 2025 онд 10 сая.тн-оор өмнөх төсөөллөөс нэмэгдэх;
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал 2024 онд 470 орчим сая ам.доллароор өмнөх оноос өсөх, 2025 онд 600 гаруй сая ам.доллароор өмнөх оноос буурах;


Эдийн засгийн өсөлт 2024 онд 3.8 хувь, 2025 онд 6.0 хувь, 2026 онд 4.6 хувьд хүрэх тооцоололтой байна (Хүснэгт 2.1). Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нийлүүлэлт болон эрэлт талаас тайлбарлав.

Нийт нийлүүлэлт

Цаг агаарын гэнэтийн хүндрэл, зудын нөхцөл байдалтай холбоотойгоор энэ оны эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 3.8 хувьд хүрч буурах хүлээлттэй боллоо. Тодруулбал, өвлийн саруудад цас эрт ахиу хэмжээгээр орж, мөсөн болон цагаан зудын эрсдэл дийлэнх аймгуудад үүсээд байгаа нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл агших, эдийн засгийн өсөлт саарах гол шалтгаан болж байна. Уул уурхай, ХАА-гаас бусад салбаруудын хувьд өсөлтийн төсөөлөл бага зэрэг буурахаар авч үзсэн бөгөөд үүнд, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ажил эхлэх хугацаа ирэх он руу хойшилж, барилгын салбарын үйлдвэрлэл удаашрах, татварын орлого бүрдүүлэлт

багасан бүтээгдэхүүний цэвэр татварын орлогын өсөлт өмнөхөөс буурах зэрэг нь гол нөлөөг үзүүлэхээр байна (Зураг 2.1).

Зураг 2.1 4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Уул уурхай: Нүүрсний экспорт энэ онд өндөр хэвээр хадгалагдаж, нүүрснээс бусад уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт өмнөх оноос нэмэгдэх нөлөөгөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэл 9.6 хувиар өсөх төлөвтэй. Оюу толгойн зэсийн баяжмалын олборлолт 2025 оноос эрчимжин уул уурхайн салбарын өсөлтийг тэтгэх хүлээлт хэвээр байна.

Хүснэгт 2.1 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл⁵

	2023	2024*	2025*	2026*
		Төсөөлөл		
ДНБ-ий өсөлт	7.0	3.8 [1.8-5.5]	6.0 [3.5-8.3]	4.6 [2.3-7.4]
Уул уурхай	23.4	9.6 [7.8-11.5]	19.5 [17.1-21.9]	3.8 [1.3-6.4]
Уул уурхайн бус	5.0	2.9 [1.0-4.7]	3.9 [1.4-6.2]	4.7 [2.5-7.6]

Эх сурвалж: Монголбанк

Уул уурхайн бус салбар: Цаг агаарын хүндрэл, зудын нөхцөл байдлаас шалтгаалан хөдөө аж ахуйн салбар энэ онд 12.2 хувиар агшихаар суурь төсөөлөлд авч үзлээ. ХАА-гаас бусад салбаруудын өсөлт 5.5 хувьд хүрэх, үүнд худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт гол эерэг нөлөөг үзүүлнэ. Төрийн албан

⁵ 30 хувийн магадлалтай итгэх интервал

хаагчдын цалин, тэтгэвэр нэмэгдэх, ЭТТ-н хувьцааны ногдол ашиг тараах зэрэг нь дотоод эрэлтийг урамшуулж, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийг тэтгэхээр байна. Харин тээвэр, мэдээлэл холбооны салбарын өсөлт өмнөх онд өндөр өссөн суурь үеийн нөлөөгөөр саарахаар байна. Дунд хугацаанд хөрөнгө оруулалт хумигдах, төсвийн төлөв чангарах зэрэг нь уул уурхайн бус салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлөх хэдий ч худалдааны нөхцөл сайжрах, уул уурхайн салбарын эерэг дам нөлөөгөөр уул уурхайн бус салбарын өсөлтийн төлөв нэмэгдэх хүлээлттэй байна.

Нийт эрэлт

Өрхийн хэрэглээ болон материаллаг эргэлтийн хөрөнгийн төсөөлөл буурсан гол нөлөөгөөр энэ оны нийт эрэлтийн төсөөлөл өмнөхөөс буурлаа (Хүснэгт 2.2). Өвөлжилт хүндэрснээр махны нийлүүлэлт хомсдох, сүүний гарц багасахын зэрэгцээ зуданд нэрвэгдсэн өрхүүдийн хэрэглээ буурах, өрхийн хүнсний хэрэглээний өсөлтийг сааруулах төлөвтэй байна. Түүнчлэн, зудын нөхцлөөс шалтгаалан малын зүй бус хорогдол нэмэгдэн малын тоо толгой буурах нь материаллаг эргэлтийн хөрөнгөд сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Дотоод эрэлт: Энэ онд эдийн засгийн өсөлтөд үзүүлэх дотоод эрэлтийн эерэг нөлөө өмнөх оноос нэмэгдэх хүлээлттэй байна. Тухайлбал, төрийн байгууллагын хэрэглээний өсөлт 14.4 хувь буюу өмнөх оноос 2 дахин нэмэгдэх, төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр үргэлжлэн өсөх, ЭТТ ногдол ашиг тараах зэрэг нь өрхийн хэрэглээг дэмжих төлөвтэй. Харин энэ онд баригдах хүлээлттэй байсан Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажил хойшилсон нь хөрөнгө оруулалт өмнөхөөс буурахад нөлөөллөө.

Ирэх онд хөрөнгө оруулалт хумигдах, төсвийн төлөв чангарах төсөөлөлтэй байгаа

тул дотоод эрэлтийн өсөлтөд үзүүлэх эерэг нөлөө буурахаар байна.

Цэвэр экспорт: Энэ онд цэвэр экспортын нийт эдийн засгийн өсөлтөд үзүүлэх эерэг нөлөө өмнөх оноос саарлаа. Тодруулбал, гол нэрийн экспортын түүхий эдийн үнэ өмнөх төсөөллөөс бага зэрэг нэмэгдэхээр байгаа ч нүүрсний экспорт өндөр өсөлттэй байсан суурь үеийн нөлөөгөөр энэ онд экспортын нэмэлт өсөлт бага гарна.

Нөгөө талаас, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өмнөх оны өндөр түвшинд байх нь машин тоног, төхөөрөмж хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортыг өсгөх хандлагатай байна. Түүнчлэн ирэх улирал ЭТТ-н ногдол ашиг бэлэн мөнгө хэлбэрээр тараагдах нь хэрэглээний импорт тэр дундаа удаан эдэлгээт хэрэглээний бүтээгдэхүүний импортыг тэлэхээр байна. Ийнхүү импортын өсөлт экспортын өсөлтөөс өндөр хадгалагдах нь нийт эрэлтийг бууруулах нөлөө үзүүлнэ.

Ирэх онд түүхий эдийн үнэ бага зэрэг буурах ч Оюу толгойн зэсийн баяжмалын экспорт нэмэгдэх, цэвэр экспортыг өсгөх хүлээлт хэвээр байна.

Хүснэгт 2.2 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, өсөлтийн бүрэлдэхүүнээр

	2023	2024*	2025*
		Төсөөлөл	
ДНБ-ий өсөлт	7.0	3.8	6.0
Дотоод эрэлт	1.8	9.6	-6.5
Цэвэр экспорт	5.2	-5.8	12.5

Эх сурвалж: Монголбанк


Эдийн засгийн цаашдын төлөвт нөлөөлж болзошгүй тодорхой бус байдал

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
БНХАУ-ын өсөлтийн төлөв саарч, аж үйлдвэрийн салбарын идэвхжил удаашрах зэргээс шалтгаалан уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт болон үнэ буурах эрсдэлтэй. Энэ тохиолдолд төсвийн орлого төлөвлөгөөнөөс буурах, эдийн засгийн өсөлт муудах эрсдэлтэй.	Дунд	Өндөр (сөрөг)
Цаг агаар, өвөлжилт, хаваржилгын нөхцөл байдал хүлээгдэж байгаагаас илүү хүндэрч, малын зүй бус хорогдол огцом нэмэгдэх нөхцөлд эдийн засгийн өсөлт хурдтай саарч болзошгүй байна.	Дунд	Өндөр (сөрөг)
Олон улсыг хамарсан геополитикийн зөрчил, хуваагдал, Израйл-Хамасын мөргөлдөөний улмаас гадаад орчны тодорхой бус байдал төдийлөн буурахгүй байна.	Бага	Бага (сөрөг)

Потенциал үйлдвэрлэл⁶

Олон хувьсагчийн Калман фильтр, нэг хувьсагчийн НР фильтр, Үйлдвэрлэлийн функцийн арга зэрэг ялгаатай аргуудаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн өсөлт 2022 оны эхнээс нэмэгдсээр тайлант улиралд 7 орчим хувьд байна.

Зураг 2.2 Потенциал үйлдвэрлэлийн өсөлт



⁶ Үйлдвэрлэлийн хүчин зүйлс хэвийн ашиглалттай үед бий болох үйлдвэрлэлийг потенциал үйлдвэрлэл гэнэ. Потенциал үйлдвэрлэл нь шууд ажиглагдахгүй тул түүхэн утгын трендээр ойролцоолон тооцдог.


Үйлдвэрлэлийн функцын аргачлалаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн өсөлтөд капитал хуримтлал, хөдөлмөр, бүтээмж зэрэг үйлдвэрлэлийн орцууд эерэг нөлөөтэй байна.

Үйлдвэрлэлийн зөрүү⁷

Ковид-19 цар тахал, ОХУ-Украины дайн, Хятадын “Тэг-Ковид” бодлого зэрэг дараалсан шокуудын нөлөөгөөр дотоод эдийн засгийн идэвхжил хумигдаж, үйлдвэрлэлийн зөрүү 2020-2022 онд сөрөг түвшинд хадгалагдлаа. Харин 2023 онд уул уурхайн салбар сэргэж, дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнээс шалтгаалан үйлдвэрлэлийн сөрөг зөрүү багасаж, нийт үйлдвэрлэл потенциал түвшин рүүгээ дөхөх хандлага хадгалагдсаар байна.

Тайлант улиралд зэс, нүүрснээс бусад уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл бага байснаар уул уурхайн үйлдвэрлэлийн зөрүү бага зэрэг буурлаа. Харин уул уурхайн бус салбарын идэвхжил 2023 оны сүүлийн хагаст нэмэгдэж, тайлант улиралд үйлдвэрлэлийн зөрүү эерэг боллоо (Зураг 2.3).

Зураг 2.3 Үйлдвэрлэлийн зөрүү⁸



⁷ Үйлдвэрлэлийн зөрүү нь потенциал үйлдвэрлэл болон бодит ДНБ-ий зөрүүгээр тодорхойлогдоно.

⁸ GAP загварын үр дүн

2.2. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл


IV улирлын эдийн засгийн өсөлтийг тоймлон авч үзвэл:

- Үйлчилгээний салбар эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн бол;
- Уул уурхай, тээврийн салбарын өсөлт удаашрав.

Нийт нийлүүлэлт

Нийт үйлдвэрлэл IV улиралд 7.2 хувь, 2023 онд 7.0 хувиар өслөө (Зураг 2.4). Экспорт оны турш сайн байж, уул уурхайн олборлолт, тэр дундаа нүүрсний үйлдвэрлэл түүхэн дээд хэмжээнд хүрэв. Үүнийг дагаад тээврийн салбарын орлого огцом нэмэгдэж, уул уурхай, тээврийн салбар дангаар 2023 оны эдийн засгийн өсөлтийн 4.3 нэгж хувийг бүрдүүлжээ. Харин хавар, өвлийн саруудын цаг агаарын таагүй байдлаас үүдэн хөдөө аж ахуйн салбар унасан байна.

Зураг 2.4 Уул уурхай болон тээврийн салбар ЭЗӨ-ийг тэтгэв



* - Боловсруулах, эрчим хүч, барилга, мэдээлэл холбоо, бусад үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татвар


Эх сурвалж: YCX

Нийт үйлдвэрлэлийн IV улирлын өсөлтийг салбаруудаар авч үзвэл:

Уул уурхайн салбарын өсөлт суурь үеэс шалтгаалан саарлаа. Тодруулбал, уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт тайлант улиралд хэвийн үргэлжилсэн хэдий ч

нүүрсний олборлолт 2022 оны IV улирлаас эхлэн эрчимжсэн суурь үеийн нөлөөгөөр жилийн өсөлт ийнхүү саарчээ (Зураг 2.5).

Зураг 2.5 Нүүрсний үйлдвэрлэл түүхэн дээд хэмжээнд хүрэв



Эх сурвалж: YCX, Монголбанк

Тээврийн салбарын орлогод уул уурхайн бүтээгдэхүүн, ялангуяа нүүрсний экспорт чухал нөлөө үзүүлсээр байна. Ийнхүү IV улиралд тээврийн салбарын нэмүү өртөг 13 орчим хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 0.8 нэгж хувийг бүрдүүлжээ.

Зураг 2.6 Уул уурхайн бус салбаруудын өсөлт, улирлаар



* - Боловсруулах, эрчим хүч, барилга, худалдаа, мэдээлэл холбоо, бусад үйлчилгээ

Эх сурвалж: YCX

Өрхийн орлогын өсөлтийг даган хэрэглээ сэргэсэн нь үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийг дэмжив. Мөн банк, санхүүгийн байгууллагын зээлийн өсөлт оны сүүлийн хагаст нэмэгдэж, хүүгийн


орлого өссөн нь санхүү даатгалын салбарын өсөлтийг тэтгэлээ (Зураг 2.6).

Газар тариалангийн үйлдвэрлэл сайн байсан боловч хөдөө аж ахуйн салбар IV улиралд 6.7 хувиар агшлаа. Дэлгэрүүлбэл, 2023 онд хаваржилт хүндэрснээс гадна оны сүүлийн улиралд нийт нутгаар хур тунадас ихээр орж малын зүй бус хорогдол нэмэгдэж, төллөлт, төл бойжилт муу байсан нь хөдөө аж ахуйн салбар оны турш агшихад нөлөөллөө.

Нийт эрэлт

Нийт эрэлт 2023 оны 4-р улиралд 7.1 хувиар, 2023 оны нийт дүнгээр 7.1 өслөө. Тайлант улирлын өсөлтийг 1) үндсэн хөрөнгийн хуримтлал, 2) өрхийн болон Засгийн газрын хэрэглээ голлон бүрдүүлэв (Зураг 2.7). Дараах хэсэгт дэлгэрүүлж тайлбарлая.


Зураг 2.7 Хэрэглээ болон экспорт нийт эрэлтийг дэмжиж байна



Нийт эрэлтийн IV улирлын өсөлтийг бүлгүүдээр авч үзвэл:


Тайлант онд нийт экспорт 42.9 хувиар огцом нэмэгдсэн ч 4-р улиралд суурь үеийн нөлөөний улмаас 5.8 хувиар буурав. 2023 онд нүүрсний экспортын биет хэмжээ 2.2 дахин нэмэгдэж, 70 орчим сая тонн буюу түүхэн дээд хэмжээнд хүрчээ (Зураг 2.8).

Зураг 2.8 Нүүрсний тээвэрлэлт хурдацтайгаар нэмэгдэж байна



Өрхийн хэрэглээ 2023 оны 4-р улиралд 14.1 хувиар өсөж, нийт эрэлтийн өсөлтийн 4.8 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Цалингийн өсөлт 4-р улиралд үргэлжлэн эрчимжиж, өрхийн бодит орлого 14.0 хувиар тэлэв. Өрхийн хэрэглээг бүтцээр нь задалбал хүнсний бус хэрэглээ өндөр өссөн хэвээр байна. Хүнсний бус хэрэглээ сүүлийн 9 улирал дараалан өсөхөд тээврийн хэрэгсэл, орон сууцны хэрэглээ голчлон нөлөөлжээ.

Зураг 2.9 Өрхийн хэрэглээ эрчимжиж байна



Хөрөнгийн нийт хуримтлал 4-р улиралд 32.9 хувиар өссөн ч жилийн дүнгээр 9.2 хувиар буурч нийт эрэлтэд 4.3 хувийн сөрөг нөлөөг үзүүллээ. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт сайн байсан болон малын тоо толгойн сөрөг өөрчлөлт зэрэг нь материаллаг эргэлтийн хөрөнгийн жилийн өөрчлөлтөд сөргөөр нөлөөлөв.

3. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

3.1. Хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөрийн захын IV улирлын төлөвийг тоймлон авч үзвэл:

- Ажилгүйдлийн түвшин статистик бүртгэж эхэлснээс хойших түүхэн доод хэмжээнд хүрч буурав.
- Бодит цалин жилийн 17 хувиар өсөв.
- Нэгж хөдөлмөрийн зардал нэмэгдлээ.

Оны эхэн үед буурч байсан хөдөлмөрийн насны хүн ам аажмаар эргэн нэмэгдэж тайлант улиралд 2162 мянгад хүрлээ. Үүнийг бүрэлдэхүүн хэсгүүдээр нь ангилж үзвэл ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо голлон өссөн байна (Хүснэгт 3.1).


Хүснэгт 3.1 Хөдөлмөрийн насны хүн амын шилжилт хөдөлгөөн

мянган хүн	2019Q4	2022Q4	2023Q3	2023Q4
Хөдөлмөрийн насны хүн ам	2132.1	2111.1	2136.6	2161.5
Ажиллах хүч	1293.6	1222.9	1259.4	1245.6
Ажиллагчид	1188.4	1158.3	1193.3	1196.8
Бүрэн хөдөлмөр эрхлэлт	1177.3	1148.4	1187.2	1189.6
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр	11.1	9.9	6.1	7.2
Ажилгүй хүн	105.1	64.6	66.0	48.8
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	838.5	888.2	877.3	915.9
Боломжит ажиллах хүч	58.0	43.4	39.9	54.9
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	780.6	844.8	837.4	861.0

Эх сурвалж: ҮСХ

Ажилгүй хүмүүсийн тоо буурах хандлага үргэлжилж, тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 24 хувиар буурч 49 мянган хүнд хүрэв. Энэ нь цар тахлын өмнөх үе буюу 2019 оны 4-р улиралтай харьцуулахад 54 хувиар бага үзүүлэлт болж байна. Харин ажиллагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.5 (3.3%) мянган хүнээр, цар тахлын өмнөх үе буюу 2019 оны 4-р улиралтай харьцуулахад 8.4 (0.7%) мянган хүнээр нэмэгдсэн байна (Хүснэгт 3.1).


Зураг 3.1 Хөдөлмөрийн насны хүн амын жилийн өөрчлөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: ҮСХ

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо өмнөх жилийн мөн үеэс 3.1 хувиар өсөв. Статистик мэдээллээс үзэхэд 2023 оны 4-р улиралд суралцагчдын тоо, тэтгэврийн насны хүн ам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өсөлт нэмэгдсэн нь нөлөөлжээ (Зураг 3.2).


Зураг 3.2 Ажиллах хүчнээс гадуурх хүн амын жилийн өөрчлөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: ҮСХ

Ажиллах хүчний оролцооны түвшний жилийн өөрчлөлтийг авч үзвэл сүүлийн 4 улирал дараалан буурлаа. Цар тахлын өмнөх жил энэ үзүүлэлт 60.1 хувьтай тэнцүү байсан бол тайлант улиралд 58.9 хувь байна. Харин ажилгүйдлийн түвшин 5.2 хувь буюу статистик бүртгэж эхэлснээс хойших хамгийн доод түвшинд хүрсэн байна (Зураг 3.3).

Зураг 3.3 Хөдөлмөрийн захын үндсэн үзүүлэлтүүд




Эх сурвалж: УСХ

Ажил эрхлэлт, нийгмийн даатгал

Нийт ажиллагчдын тооны жилийн өөрчлөлт 2023 он гарсаар эхний 2 улирал дараалан буурсан бол оны 2-р хагаст эргэн өссөн байна. Тодруулбал, боловсруулах, барилга, худалдаа, тээврийн салбарт ажиллагчдын тоо нэмэгдэж хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт ажиллагчид буурчээ (Зураг 3.4).

Нийгмийн даатгалд хамрагдагчдын тоо 2023 оны 12-р сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар өсөөд байна. Үүнд албан журмаар даатгуулагчдын тоо жилийн 4.1 хувиар өссөн нь нөлөөлөв.

Зураг 3.4 Ажиллагчдын тооны жилийн өөрчлөлт, салбараар



Эх сурвалж: УСХ

Цалин, өрхийн орлого

Улсын дундаж цалин 2023 оны 4-р улиралд жилийн өмнөхөөс 27.7 хувиар өссөн бол медиан цалин 38.6 хувиар өслөө. Ингэснээр дундаж цалин 2235 мянган төгрөг⁹, медиан цалин 1781 мянган төгрөгтэй тус тус тэнцэж байна. Цалин ийнхүү нэмэгдсэн нь өрхийн орлогыг нэмэгдүүлж байна. Сүүлийн 6 улиралд нэрлэсэн цалин өндөр өсөж, инфляц буурах хандлагатай байгаагаас шалтгаалж бодит цалингийн өсөлт эрчимжиж, тайлант улиралд жилийн 17 хувиар өслөө (Зураг 3.5).

Зураг 3.5 Цалингийн өсөлт ба өрхийн орлогын өсөлт



Эх сурвалж: УСХ

Эдийн засгийн голлох салбаруудаар авч үзвэл төрийн удирдлага (61%), боловсрол (35%), хөдөө аж ахуй (33%), эрчим хүч (30%), барилга (27%)-н салбарт ажиллагчдын дундаж нэрлэсэн цалин хамгийн өндөр өсжээ. Харин худалдаа (15%), уул уурхай (18%), мэдээлэл холбоо (19%), боловсруулах (20%), санхүү, даатгал (20%)-ын салбарт алба хаагчдын цалингийн өсөлт харьцангуй бага байна.

Нэгж хөдөлмөрийн зардал


Нэгж хөдөлмөрийн зардал¹⁰ сүүлийн 2 жил дараалан алгуур өссөөр байна. Тодруулбал, цалингийн өсөлт бүтээмжийн өсөлтөөс үлэмж өндөр байгаа нь үйлдвэрлэлийн

⁹ 2019 оны мөн үетэй харьцуулахад 79.9 хувиар өссөн

¹⁰ Нэгж ДНБ-д ногдох дундаж хөдөлмөрийн өртөг буюу цалин.

зардлыг нэмэгдүүлж, улмаар үнэ өсөх гол шалтгаан болж болзошгүй байна (Зураг 3.6).

Зураг 3.6 Нэгж хөдөлмөрийн дундаж зардлын жилийн өөрчлөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: УСХ

3.2. Мөнгө, санхүүгийн зах зээл

3.2.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд


Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эрчимжих хандлага тогтворжсон бол зээлийн өсөлт үргэлжлэн нэмэгдлээ.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2023 онд эрчимжиж 2023 оны 12 дугаар сард 26.8 хувьд хүрээд байсан бол 2024 он гарснаар тогтворжиж, 26.1 хувьд хүрэв. Тайлант улиралд мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эрчимжихэд зээлийн өсөлт сэргэсэн нь голлон нөлөөллөө. Түүнчлэн, гадаад цэвэр актив (ГЦА)-ын өсөлт үргэлжлэн нэмэгдсэн бөгөөд нэгдсэн төсөв 2023 оны 4 дүгээр улиралд 1.4 их наяд төгрөгийн алдагдалтай байснаар Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ)-ийн мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөө буурсан байна.

Харин 2024 он гарснаар нэг талаас төлбөрийн тэнцэлтэй холбоотой ГЦА-ын өсөлт саарсан, нөгөө талаас зээлийн өсөлт нэмэгдэж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2024 оны 1 дүгээр сард 26.1 хувьд¹¹ хүрлээ (Зураг 3.7).

¹¹ Үүнд, ГЦА 18.6 нэгж хувь, зээл 18.9 нэгж хувь, ЗГЦЗ -4.8 нэгж хувийн нөлөө үзүүлэв.


Зураг 3.7 М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал



Эх сурвалж: Монголбанк

Эх үүсвэр талаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг төгрөгийн харилцах, хадгаламж бүрдүүлсэн хэвээр байна. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлт өсөлтийн 14.6 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 6.6 нэгж хувийг төгрөгийн харилцах бүрдүүлэв. Харин гадаад валютын харилцах 6.4 нэгж хувь, гадаад валютын хадгаламж -1.8 нэгж хувийн нөлөөг тус тус үзүүлжээ.

Зураг 3.8 М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал




Эх сурвалж: Монголбанк

Улмаар банкны системийн эх үүсвэрийн долларжилт 2024 оны 1 дүгээр сард 31.7 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.6 нэгж хувиар буурсан бол өмнөх сараас 2.9 нэгж

Инфляцын тайлан 2024 оны 3 дугаар сар

хувиар нэмэгдсэн¹² дүн юм. Ханшийн нөлөөг хасаж тооцвол эх үүсвэрийн долларжилт 26.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар буурсан байна (Зураг 3.9).

Зураг 3.9 Банкуудын зээл болон эх үүсвэрийн долларжилт




Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн зээлийн жилийн өсөлт 2024 оны 1 дүгээр сард 23.5 хувьд хүрч, үргэлжлэн эрчимжлээ (Зураг 3.10). Зээлийн зориулалтаар нь харвал хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл жилийн 41.8 хувиар¹³, ипотекийн зээл¹⁴ жилийн 18.7 хувиар өсөж, өсөлтийн хурд нь нэмэгдсэн байна. Түүнчлэн, сүүлийн улирлуудад өсөлт нь нам түвшинд хадгалагдаад байсан бизнесийн зээл өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар өсөж, өсөлт нь сэргэв. Эдийн засгийн салбараар авч үзвэл, бүх салбарт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс өссөн бөгөөд тэр дундаа худалдаа, үйлчилгээ, боловсруулах салбарын зээлийн өсөлт бизнесийн зээлийн өсөлтийг голлон бүрдүүлж байна (Зураг 3.10).

Валютын төрлөөр нь авч үзвэл төгрөгийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 23.4 хувиар, гадаад валютын зээлийн үлдэгдэл 26.5 хувиар нэмэгдэж, зээлийн долларжилт

6.0 хувийн орчимд тогтвортой байна (Зураг 3.9).


Зураг 3.10 Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн



Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеийн түвшинд байгаа бол анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл бага зэрэг нэмэгдсэн байна. Тухайлбал, чанаргүй зээлийн үлдэгдэл 2024 оны 1 дүгээр сард 2.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22 тэрбум төгрөгөөр буюу 1.1 хувиар өсөв.

Зураг 3.11 Банкны системийн чанаргүй зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

¹² Улсын байгууллагын гадаад валютын харилцах нэмэгдсэн нь нөлөөлөв.

¹³ Хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээлийн өсөлтийн 22.1 нэгж хувийг цалингийн зээл, 11.0 нэгж хувийг тэтгэврийн зээл бүрдүүлж байна.

¹⁴ Ипотекийн зээлээр баталгаажуулсан бонд оруулж тооцсон.

Үүнд, боловсруулах болон худалдааны салбарын чанаргүй зээл өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бол бусад бүх салбарт чанаргүй зээлийн үлдэгдэл буурчээ. Ийнхүү чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 7.4 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар бага дүн юм (Зураг 3.11).

Банкны системийн анхаарал хандуулах зээлийн өсөлт 2023 оны 1 дүгээр улирлаас хойш саарах хандлагатай байна (Зураг 3.12). Тодруулбал, 2024 оны 1 дүгээр сарын байдлаар анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 82 тэрбум төгрөг буюу 7.2 хувиар нэмэгдэж, 1.2 их наяд төгрөгт хүрлээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал боловсруулах, уул уурхайн салбарын анхаарал хандуулах зээл голлон өссөн бол барилга, худалдаа, эрчим хүчний салбарын анхаарал хандуулах зээл буурчээ. Улмаар анхаарал хандуулах зээл нийт зээлийн багцын 4.4 хувийг бүрдүүлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурсан дүн болж байна.

Зураг 3.12 Банкны системийн анхаарал хандуулах зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

¹⁵ 2023 оны 3 дугаар улиралтай харьцуулахад

¹⁶ Банкуудын зах зээлийн хүүгээс доогуур буюу Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй хөтөлбөр,

3.2.2. Хүү

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 1 дүгээр улирлын ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 12 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Тайлант хугацаанд банк хоорондын захын хүүнүүд хүүний коридорын голчийн орчимд тогтвортой байв.

Зураг 3.13. БХЗ-ын хэлцлийн хүү



Эх сурвалж: Монголбанк


Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2024 оны 1 дүгээр сард 13 хувь буюу өмнөх улирлын¹⁵ орчимд байна. Үүнд, ТБҮЦ барьцаалсан репо хэлцэл болон ТБҮЦ-ны шууд хэлцэл 13.0 хувийн орчимд өөрчлөлт багатай байсан нь голлон нөлөөлөв. Харин банк хоорондын захын хадгаламжийн хүү 13.43 хувьд хүрч, өмнөх улиралтай харьцуулахад 0.2 нэгж хувиар өссөн, овернайт зээл 13.18 хувь буюу өмнөх улирлаас 0.18 хувиар нэмэгдсэн байна (Зураг 3.13).

Банкуудын шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх улирлаас 0.46 нэгж хувиар өсөж 11.45 хувьд, шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 0.22 нэгж хувиар нэмэгдэж 16.74 хувьд хүрэв. Харин хөнгөлөлттэй зээлийг¹⁶ хасаж тооцвол

төлөвлөгөөний хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлтэй олгосон зээл

шинээр олгосон зээлийн хүү өмнөх улирлаас 0.16 нэгж хувиар өсөж 16.97 хувьд хүрсэн байна. Ийнхүү хадгаламжийн хүү өссөн нөлөөгөөр зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх улирлаас 0.24 хувиар буурч 5.29 хувьд хүрсэн байна (Зураг 3.14).

Зураг 3.14 Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү, төгрөг




* Нийт зээлийн хүүнээс тооцсон

Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү өмнөх улирлаас буурсан бол шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү нэмэгдлээ. Тодруулбал, шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү 2024 оны 1 дүгээр сард 10.05 хувьд хүрч өмнөх улирлаас 0.26 нэгж хувиар буурсан бол шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү 3.45 хувьд хүрч өмнөх улирлаас 0.15 нэгж хувиар өссөн байна. Улмаар гадаад валютын зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх улирлаас 0.41 нэгж хувиар буурч 6.6 хувьд хүрлээ (Зураг 3.15).

Зураг 3.15. Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү, гадаад валют




Эх сурвалж: Монголбанк

3.2.3 Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сүүлийн хагас жил гаруйн хугацаанд үргэлжлэн чангарч, 3 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 3376.7 төгрөгтэй тэнцэж байна. Энэ нь оны эхнээс 34 төгрөгөөр буюу 1.0 хувиар чангарсан үзүүлэлт юм (Зураг 3.16).

Төгрөгийн ханш ам.долларын эсрэг ийнхүү чангарахад нүүрсний экспорт эрчимжин экспортын орлого нэмэгдэж, гадаад валютын урсгал цэвэр дүнгээр сүүлийн 14 сарын турш ашигтай гарсан нь голлон нөлөөлж байна.


Зураг 3.16 Төгрөгийн ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Монголбанк

Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн ханш (NEER) энэ оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар чангарлаа (Зураг 3.17). Тайлант сард төгрөгийн ханш ам.долларын эсрэг өмнөх оны оны мөн үеэс 2.6 хувиар чангарсан бол рублийн эсрэг 23.6 хувиар, юанийн эсрэг 8.4 хувиар, еврогийн эсрэг 2.6 тус тус чангарч, нэрлэсэн ханш ийнхүү чанга тогтлоо (Зураг 3.18).


Зураг 3.17 Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханш



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн нэрлэсэн ханш чангарахтай зэрэгцэн гадаад үнэтэй харьцуулахад дотоод үнэ өндөр байгаа нь бодит ханш чангарах шалтгаан болж байна. Тодруулбал, бодит ханш энэ оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар чангарсан байна. Төгрөгийн бодит ханш ийнхүү чангарч байгаа нь импортын бараа, үйлчилгээ хямдрах, цаашлаад урсгал дансны тэнцэлд дарамт учруулах эрсдэлтэйг илтгэж байна. Бодит ханш чангарахад гол нөлөө үзүүлсэн нэрлэсэн үйлчилж буй ханшийн чангарсан нь рублийн ханш суларсантай холбоотой.


Зураг 3.18 Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн харьцангуй өгөөж сүүлийн жил орчмын хугацаанд эерэг дүнтэй байж, энэ оны 2 дугаар сарын байдлаар 1.1 хувьтай байна. Төгрөгийн харьцангуй өгөөж ийнхүү эерэг байгаа нь төгрөгийн харилцах, хадгаламж өсөж, валютын харилцах, хадгаламж буурах нөлөөг үзүүлж байна (Зураг 3.19).

Зураг 3.19 Төгрөгийн харьцангуй өгөөж



Эх сурвалж: Монголбанк

3.2.4. Хөрөнгийн зах зээл

Тайлант улиралд орон сууцны үнэ өсөж, хөрөнгийн зах зээлийн идэвхжил нэмэгдлээ.


Орон сууцны зах зээл

Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээллээр орон сууцны үнэ 2023 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 3.4 хувиар, түрээсийн үнэ 2.4 хувиар тус тус өслөө. Үүнээс шинэ орон сууцны үнэ өмнөх

улирлаас 4.4 хувиар, хуучин орон сууцны үнэ 2.4 хувиар тус тус нэмэгджээ (Зураг 3.20).

Орон сууцны үнэ ийнхүү нэмэгдэхэд цалин, тэтгэвэр өсөж, өрхийн орлогыг дэмжсэнээс гадна орон сууцны зээлийн санхүүжилт 2023 онд нэмэгдсэн¹⁷ нь эрэлтийг өсгөж, үнэ өсөх нэг хүчин зүйл болж байна. Тодруулбал, тайлант улиралд шинээр олгосон орон сууцны ипотекийн зээлдэгчдийн тоо өмнөх улирлаас 40 орчим хувиар, өмнөх оны мөн үеэс 27 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 3.20 Орон сууцны үнэ ба түрээсийн үнийн жилийн өсөлт




Эх сурвалж: ҮСХ, Тэнхлэг-Зууч

Харин “Тэнхлэг зууч ХК”-ий мэдээллээр тайлант улиралд түрээсийн үнэ өмнөх улирлаас буурсан бол орон сууцны үнэ өөрчлөлт багатай байлаа. Тодруулбал, түрээсийн үнэ өмнөх улирлаас 1.4 хувиар буурч, орон сууцны үнэ өмнөх улирлаас 0.2 хувиар саарсан байна. ҮСХ болон “Тэнхлэг зууч ХК”-ий мэдээлдэг орон сууцны үнэ ийнхүү ялгаатай байгаа нь түүврийн эх сурвалж, бүсчлэл, байрлалаас гадна Тэнхлэг зууч компанийн мэдээлэлд өндөр

зэрэглэлийн болон бизнес ангиллын орон сууц харьцангуй өндөр жин эзэлдэг.

ҮСХ-ны тооцоолсон ОСҮИ-ээр орон сууцны зах зээлийн төлөвийг илтгэх харьцаа үзүүлэлтийг тооцвол өрхийн бодит орлого өмнөх улирлын орчимд байж, орон сууцны үнэ өссөн нөлөөгөөр үнэ-орлогын харьцаа бага зэрэг нэмэгдлээ. Энэ үзүүлэлт нь өмнөх улирлаас бага зэрэг өссөн хэдий ч өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй нам түвшинд байгаа нь өрхийн орон сууц худалдан авах чадвар сайжирсныг илтгэж байна.

Зураг 3.21 Үнэ-орлого ба үнэ-түрээсийн харьцаа



Эх сурвалж: ҮСХ, Тэнхлэг-Зууч

Харин орон сууцны үнэ болон түрээсийн үнийн өсөлт ойролцоо байснаар үнэ-түрээсийн харьцаа өмнөх улирлын орчимд хадгалагдав. Энэ харьцаа сүүлийн 4 улирлын турш тогтвортой байгаа нь орон сууцны үнэ хэт өсөх эрсдэл нэмэгдээгүйг харуулж байна.

Барилгын өртгийн өсөлт сүүлийн улирлуудад тогтворжлоо. Тодруулбал, барилгын өртөг өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар өссөн бол өмнөх улиралтай

¹⁷ ОСИСТТБ хөтөлбөрийн санхүүжилт 2023 онд өмнөх оноос 24 хувиар, банкны эх үүсвэрээрх санхүүжилт өмнөх оноос 67 хувиар тус тус өссөн.

харьцуулахад өөрчлөлтгүй байна (Зураг 3.22). Ийнхүү барилгын өртөг тогтворжиж өмнөх улирлын түвшинд хадгалагдахад төгрөгийн ханш чангарсан, импортын бараа, материалын үнэ тогтворжсон, дотоодын цементний үнэ сүүлийн саруудад буурч эхэлсэн зэрэг нь голлон нөлөөлж байна. Тухайлбал, бараа материалын өртөг өмнөх улирлаас 5.9 хувиар буурч, барилгын өртгийн өсөлтийг 3.5 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлсэн бол цалингийн зардал өмнөх улирлаас 6.7 хувиар өсөж, барилгын өртгийн өсөлтийг 6.6 нэгж хувиар нэмэгдүүлсэн байна

Зураг 3.22 Орон сууцны барилгын өртгийн индекс (БӨИ)



Эх сурвалж: УСХ


Хөрөнгийн зах зээл

Тайлант улиралд хөрөнгийн зах зээлийн идэвхжил нэмэгдлээ. Тодруулбал, 2023 оны 4 дүгээр улиралд арилжааны идэвх өмнөх улирлаас 10.2 хувиар, ТОП-20 индекс өмнөх улирлын дунджаас 2.7 хувиар, зах зээлийн үнэлгээ 2.1 хувиар тус тус өслөө (Зураг 3.23).

Инвекор ББСБ ХК, Таван толгой ХК компаниудын хувьцааны үнэ өсөж ТОП-20 индекс өмнөх улирлаас нэмэгдлээ. Мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ) болон хувьцааны арилжааны идэвх

нэмэгдсэн нь нийт арилжааны дүн өмнөх улирлаас өсөхөд голлон нөлөөллөө. Ийнхүү үнэт цаасны арилжааны дүн 2023 оны 4 дүгээр улиралд 111.7 тэрбум төгрөг болж өмнөх улирлаас 10.2 хувиар өслөө (Зураг 3.24).


Зураг 3.23 Хөрөнгийн захын голлох үзүүлэлтүүд



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Хувьцааны анхдагч зах зээл дээр тайлант улиралд арилжаа хийгдээгүй бол хоёрдогч зах зээлд нийт 51.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, хувьцааны нийт арилжаа өмнөх улирлаас 37.8 хувиар өслөө. Тодруулбал, хувьцааны хоёрдогч зах зээлд Инвекор ББСБ (13.0 тэрбум төгрөг), АПУ ХХК (5.6 тэрбум төгрөг), Хаан банк (4.1 тэрбум төгрөг) ХК-иудын хувьцаа хамгийн идэвхтэй арилжигдав.

Зураг 3.24 Нийт арилжаа, бүтцээр¹⁸



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

¹⁸ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ), Хөрөнгө оруулалтын сан (ХОС)

Компанийн бондын арилжааны хувьд анхдагч зах зээлд Ашид Капитал ББСБ 15 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий Симпл-II бонд, Хаан банк ХХК 17 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий “Ногоон бонд” арилжсан. Хоёрдогч зах зээлд нийт 9.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий компанийн бонд арилжигдсан нь өмнөх улирлаас 17 хувиар буурсан дүн юм. Ийнхүү компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа идэвх буурч нийт хийгдсэн арилжааны дүн өмнөх улирлаас 31.4 хувиар буурлаа.

ХБҮЦ-ны арилжааны анхдагч зах зээл болон хоёрдогч зах зээлийн арилжаа нэмэгдэж, нийт хийгдсэн арилжааны дүн 18.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх улиралтай харьцуулахад арилжааны идэвх огцом нэмэгдэв. Тодруулбал, анхдагч зах зээл дээр Омни ассет ТЗК 6.0 тэрбум төгрөгийн ХБҮЦ гаргаж арилжсан ба хоёрдогч зах зээлийн арилжааны идэвх мөн сайн байв. Харин ХОС-ийн нийт 0.6 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, арилжааны идэвх өмнөх улиралтай харьцуулахад буурлаа.

3.3. Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр

Нэгдсэн төсөв: 2023 онд төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 35.0 хувиар өндөр төвлөрч, 23.2 их наяд төгрөгт хүрсэн бол зардал 23.5 хувиар их буюу 22.5 их наяд төгрөг зарцуулжээ. Тэнцвэржүүлсэн тэнцэл 0.8 их наяд төгрөгийн ашигтай байна (Хүснэгт 3.2).

Тэнцвэржүүлсэн орлого 2023 онд: Орлого бүх дэд бүлгүүдээрээ өмнөх оноос өссөн байна. Энэ нь чулуун нүүрс болон хүрэн нүүрсний экспортын хэмжээ 2023 онд 66.7 сая тонн, хүрэн нүүрс 2.9 сая тоннд тус тус хүрч нийлбэр дүнгээр 69.6 сая.тонн буюу түүхэн дээд хэмжээнд хүрсэн, эдийн засгийн өсөлт өндөр байгаа зэрэгтэй


холбоотойгоор АМНАТ-ын орлого өмнөх оноос 103 хувь буюу 1.8 их наяд төгрөгөөр, ААНОАТ мөн өмнөх оноос 1.4 их наяд төгрөг буюу 51.6 хувиар өсөв (Зураг 3.25).

Хүснэгт 3.2 Төсвийн үндсэн үзүүлэлтүүд

Их наяд төгрөг	2022	2023	2023	
	Гүй.	Тод.	Гүй.	Гүй%
Нийт орлого	18.6	21.8	24.3	111%
Сангийн орлого	1.4	1.0	1.1	105%
Тэнцвэржүүлсэн орлого	17.2	20.8	23.2	112%
Татварын орлого	15.6	18.9	18.9	113%
Татварын бус орлого	1.6	1.9	1.8	95%
Нийт зардал	18.2	22.4	22.5	100%
Анхдагч зардал	17.4	21.3	21.3	100%
Хүүний зардал	0.8	1.1	1.1	104%
Нийт тэнцэл	0.4	-0.5	1.9	
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	0.9%	-0.9%	0.0	
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1.0	-1.6	0.8	
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	-2.1%	-2.6%	0.0	
Анхдагч тэнцэл	-0.2	-0.5	1.9	
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	-0.3%	-0.8%	0.0	

Эх сурвалж: Сангийн яам

Зураг 3.25 Төсвийн орлогын бүтэц, 2023 онд




Эх сурвалж: Сангийн яам

Нийт зардал, цэвэр зээл 2023 онд:

Төсвийн нийт зардал 2023 онд өмнөх оноос 23.5 хувиар буюу 4.3 их наяд төгрөгөөр өндөр байв. Үүнээс, урсгал зардал 2.8 их наяд төгрөгөөр нэмэгдсэний 1.3 их наяд төгрөгийг бараа, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Мөн цалингийн зардал 665 тэрбум төгрөгөөр нэмэгдэж жилийн өмнөх мөн үеэс 40 хувиар өсөв.

Зураг 3.26 Төсвийн зардлын бүтэц, 2023 онд



Эх сурвалж: Сангийн яам

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр: Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь 2023 онд 37.6 хувь байсан нь хуульд¹⁹ заасан хязгаарыг хангаж байна (Хүснэгт 3.3). Төсвийн тодотголоор үүнд өөрчлөлт ороогүй.

Хүснэгт 3.3 Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өр болон зээлийн үйлчилгээний төлбөр

тэрбум төгрөг	2021	2022	2023	2024*
	Гүй.	Гүй.	Гүй.	Бат.
Засгийн газрын нийт өр (ӨҮЦ)	21837	27679	26643	39276
ДНБ-д эзлэх хувь	50.1	52.4	37.8	60.0
Өрийн хязгаар	70.0	70.0	65.0	60.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	828	816	1132	1174
Төсвийн орлогод эзлэх хувь	6.5	4.7	4.9	4.5
Төсвийн тэнцэл	-2909	-979	763	-1833
ДНБ-д эзлэх хувь	-4.5	-1.9	1.1	-2.8

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк


4. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН

4.1 Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл

Гадаад эрэлт: Дэлхийн эдийн засгийн өсөлт 2023 онд олон улсын байгууллагуудын төсөөллөөс давж 3.1 хувь гарав. АНУ, ОХУ-ын эдийн засгийн өсөлт өмнөх оны сүүлийн улиралд хүлээлтээс

өндөр байсан нь үүнд том нөлөөтэй байв. Цаашид томоохон эдийн засгуудын өсөлт нэмэгдэж байгаатай холбоотойгоор дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл өмнөхөөс нэмэгдлээ.

Зураг 4.1 Улс орнуудын өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Блүмберг, Рубини, EIU, ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын төсөөллийн дундаж

ОХУ-Украин, Ойрх Дорнодод өрнөж буй мөргөлдөөнүүд, худалдааны онгоцууд руу дайрах дайралтаас шалтгаалж эдийн засгийн өсөлтийн төсөөлөлд нөлөөлөх геополитикийн эрсдэл өндөр хэвээр байна. Дараах хэсэгт сонгосон орнуудын төлөвийг дэлгэрүүлж тайлбарлая:

БНХАУ-ын өсөлт 2023 онд хүлээлтийн дагуу **5.2 хувьтай** гарав. Хэдийгээр тус улсын үл хөдлөхийн салбарын уналтаас шалтгаалж өмнөх жилүүдтэй харьцуулахад өсөлтийн тренд буурахаар хүлээгдэж байгаа ч төсөв, мөнгөний тэлэх бодлогын нөлөөгөөр 2024-2025 онуудад эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс 0.1 нэгж хувиар өндөр буюу **4.5 хувьд тогтвортой** байхаар байна.

АНУ-ын эдийн засаг 2023 оны 4-р улиралд шинжээчдийн хүлээлтээс давж 3.2 хувиар өсөв. Ийнхүү өсөлт өндөр гүйцэтгэлтэй гарахад тус улсын хувийн хэрэглээ хурдтай

¹⁹ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2023 онд 65, 2024 онд 60 хувиас хэтрүүлэхгүй байхаар заажээ.

сэргэсэн, цар тахлын үеийн нийлүүлэлтийн сүлжээний доголдол хүлээлтээс хурдтай засагдаж байгаа зэрэг нь нөлөөлж байна. Цалингийн өсөлтөөс үүдэлтэй өрхүүдийн зээлийн хэмжээ, тэр дундаа автомашин болон кредит картын зээл хамгийн их өсөж, өрхүүдийн өрийн хэмжээ түүхэн өндөр түвшинд хүрсэн нь хувийн хэрэглээ нэмэгдэх гол шалтгаан боллоо. Энэхүү хэрэглээний өсөлт цаашид ч үргэлжилж 2024 оны эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс 0.4 нэгж хувиар нэмэгдэж, 1.4 хувьд хүрэхээр байгаа бол 2025 оны өсөлт өмнөхийн адил 1.8 хувь байхаар байна.

Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2023 онд хүлээлтийн орчимд байж өмнөх оноос 0.5 хувиар өсөв. Европын төв банк бодлогын хүүгээ эрчтэй өсгөсөн шийдвэрүүдийн нөлөө Европын холбооны эдийн засгийн өсөлт, санхүүгийн зах зээлд хүчтэй илэрч, улмаар ийнхүү өсөлт удаашраад байна. Тус бүсийн хамгийн том эдийн засаг болох Германы эдийн засаг сүүлийн 2 улирал дараалан жилийн өмнөх үеэс буурч гарсан нь цаашид Евро бүсийн өсөлтийн төсөөлөл саарахад том жинтэй байв. Үүнээс гадна ИБУИНВУ-ын ДНБ-ий улирлын өсөлт 2 улирал дараалан сөрөг гарч хүндрэлийн дохио өгч байна.

ОХУ-ын 2023 оны эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл хараахан зарлагдаагүй байгаа ч өмнөх улиралд хийж байсан төсөөллөөс өндөр гарах нь тодорхой болоод байна. Үүнд, зэвсэгт хүчний зардал нэмэгдсэн, цалингийн өсөлтөөс шалтгаалж өрхийн хэрэглээ тэлсэн зэрэг нь өсөлт хүлээлтээс өндөр гарах шалтгаан болж байна. Энэ онд ч дээр дурдсан хүчин зүйлсээс шалтгаалж эдийн засгийн өсөлт 0.6 нэгж хувиар нэмэгдэхээр байгаа бол 2025 оны өсөлт өмнөх төсөөллийн орчимд буюу 1.0 хувь байхаар байна.

Гадаад инфляц: Дэлхийн ихэнх оронд инфляцын эрч саарсаар байгаа ч төв банкуудын зорилтог түвшинээс өндөр хэвээр байна. АНУ-ын инфляц 2024 оны 1-р сард 3.1 хувь гарав. Энэ нь шинжээчдийн хүлээлтээс өндөр гүйцэтгэл тул хөрөнгө оруулагчид энэ оны 5 сард ХНБ-ны бодлогын хүү буурч эхлэх хүлээлтээ 1 сараар хойшлуулав.

Евро бүсийн инфляц өмнөх оны 1-р сард жилийн 8.6 хувь байсан бол түүнээс хойш буурах хандлага үргэлжлэн 2024 оны эхний сард 2.8 хувьд хүрлээ.

БНХАУ-д энэ оны 1-р сарын байдлаар өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ жилийн 0.8 хувиар буурлаа. Тус улсын дотоодын эрэлт сул байгаатай холбоотойгоор ийнхүү 4 сар дараалан дефляц тохиогоод байна. Харин суурь инфляц 1-р сард 0.4 хувьтай байв.

ОХУ-д инфляц 2024 оны эхний сард 7.4 хувьтай гарав. Тус улсад хүнсний бус хэрэглээний үнэ өсөж буй нь инфляцын гол шалтгаан болоод байна.

Гадаад хүү: ХНБ 1-р сарын хурлаар бодлогын хүүг 5.5 хувьд хэвээр хадгалав. Инфляц шинжээчдийн хүлээлтээс өндөр гарсан тул хөрөнгө оруулагчид энэ оны 5 сард ХНБ-ны бодлогын хүү буурч эхлэх хүлээлтээ 1 сараар хойшлуулав. Цаашид инфляц хэр хурдтай буурахаас хамаарч ХНБ-ны бодлогын хүү тодорхойлогдохоор байна. Инфляцын түвшин буурч байгаагаас шалтгаалан энэ оны 2-р хагасаас Европын төв банк бодлогын хүүгээ бууруулж эхлэх хүлээлттэй байна.

4.2. Экспортын үнийн төлөв

Зэс: Зэсийн үнэ 2024 оны 1-р сард 8609 ам.доллар/тн байв. Гүйцэтгэл өмнөх удаагийн төсөөллийн орчимд байгаа бөгөөд цаашдын төсөөлөлд ч томоохон өөрчлөлт ороогүй байна. Хэдийгээр БНХАУ-ын өсөлт өмнөх жилүүдээс саарч байгаа ч тус улсын

цахилгаан машин, сэргээгдэх эрчим хүч, цахилгаантай холбоотой дэд бүтцийн ажлууд эрчимжсэнээр зэсийн эрэлт нэмэгдэж, үнэ өсөх тооцооллыг олон улсын байгууллагууд боловсруулаад байна.

Алт: Алтны үнэ 1-р сарын дунджаар 2040 ам.доллар/унци буюу харьцангуй өндөр түвшинд хадгалагдсан хэвээр байна. ХНБ бодлогын хүүгээ бууруулах талаар хүлээлт үүссэн, геополитикийн хурцадмал байдал ээлж дараалан бий болж байгаа зэрэг нь алтны эрэлтийг өсгөж, үнэ өндөр байх нөхцлийг бий болгов.


Коксжих нүүрс: Коксжих нүүрсний хилийн үнэ 2023 оны сүүлийн улиралд хүлээлтээс 9 ам.доллар/тн-оор өндөр гүйцэтгэлтэй гарав. Өмнөх онд БНХАУ-д эхэлсэн уурхайн аюулгүй ажиллагааны хяналт шалгалтын арга хэмжээ, түүнчлэн тус улс 2023 онд гангийн үйлдвэрлэлдээ хязгаар тогтоогоогүй зэрэг нь үнэ өндөр байх гол шалтгаан болов. Цаашид уурхайн хяналт шалгалтын ажил дуусаж, БНХАУ-ын импортын нүүрсний эрэлт буурснаар манай улсын экспортын нүүрсний хилийн үнэ буурах хүлээлттэй байгаа ч өмнөх төсөөлөлтэй харьцуулахад тонн тутамдаа 5 ам.доллараар өндөр байх юм. Үүнд, манай улс цаашид биржээр борлуулах нүүрсний хэмжээгээ өсгөж, улмаар борлуулж буй нүүрсний дундаж үнэ нэмэгдэхээр байгаа нь нөлөөллөө.

Төмрийн хүдэр: 1-р сарын дунджаар тонн тутамдаа 127 ам.доллар болж жилийн өмнөхөөс 8.7 хувиар нэмэгджээ. БНХАУ-ын ЗГ-аас 2023 онд гангийн үйлдвэрлэлдээ хязгаар тогтоогоогүй нь төмрийн хүдрийн эрэлт өндөр байж, үнэ нэмэгдэхэд нөлөөллөө. Цаашид БНХАУ-ын эдийн засгийн өсөлт өмнөх онуудаас саарах, үл хөдлөхийн салбарын хүндрэл үргэлжлэхээр байгаатай холбоотойгоор төмрийн хүдрийн үнэ буурах хүлээлт хэвээр болно.

Газрын тос: Брент газрын тосны үнэ 1-р сарын дунджаар 81.7 ам.доллар/баррель байв. Сауди Араб, ОХУ тэргүүтэй (ОПЕК+)-ийн орнууд газрын тосны нийлүүлэлтээ хязгаарлаад буй ч (ОПЕК+)-д хамаардаггүй АНУ зэрэг орнуудын газрын тосны нийлүүлэлт өндөр хэвээр байна. Улмаар өмнөх төсөөлөлтэй харьцуулахад төдийлөн өөрчлөлт гараагүй байна. Нэг талаас, ОПЕК-н орнуудын нийт газрын тос олборлолтын 3.5 хувийг бүрдүүлдэг Ангол улс 2024 оны 1-р сарын 1-нээс эхлэн ОПЕК-оос гарч байгаа нь цаашдын газрын тосны нийлүүлэлтэд эерэг дохио болж байна. Нөгөө талаас, Ойрх Дорнодод өрнөж буй мөргөлдөөн, улаан тэнгист худалдааны онгоцууд руу Йемений босогчид довтолж буй нь газрын тосны тээвэрт шинэ эрсдэл үүсгэлээ.

Худалдааны нөхцөл: Экспортын үнийн төсөөлөл нэмэгдсэн тул худалдааны нөхцөлийн жилийн өөрчлөлт өмнөх төсөөллөөс сайжирлаа (Зураг 4.2). Ойрын 2 жилд импортын үнийн өсөлт харьцангуй бага байх бол экспортын үнэ буурч, худалдааны нөхцөл муудах хүлээлт хэвээр байна.

Зураг 4.2 Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

4.3. Төлбөрийн тэнцэл


Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2023 оны IV улиралд 666 сая ам.доллар, 2023 онд 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Мөн сүүлийн 16 жилийн турш алдагдалтай байсан урсгал данс 2023 онд 147 сая ам.долларын ашигтай гарсан нь эдийн засгийн тогтвортой байдалд дэмжлэг болж байна.

Төлбөрийн тэнцэл ийнхүү ашигтай байж, гадаад валютын нөөц нэмэгдэхэд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- Нүүрсний экспортын биет хэмжээ түүхэн дээд түвшинд хүрч нэмэгдсэн;
- Оюу толгойн хөрөнгө оруулалт болон хувийн секторын гадаад зээлийн санхүүжилт санхүүгийн дансны орох урсгалыг бүрдүүлсэн.

Зураг 4.3 Төлбөрийн тэнцэл 2023 оны IV улиралд 666 сая ам.долларын ашигтай байв



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн тэнцлийг гол бүрэлдэхүүн хэсгүүдээр дэлгэрүүлж тайлбарлавал:

Экспортын орлого 2023 оны IV улиралд өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар өсөв. Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ тухайн онд 66.7 сая тоннд хүрч нэмэгдсэн, Оюу толгойн далд уурхайн зэсийн баяжмалын үйлдвэрлэл хүлээлтээс өндөр байгаа нь

экспортын орлогын өсөлтийн томоохон хэсгийг бүрдүүлэв. Түүнчлэн, мах, махан бүтээгдэхүүний экспорт энэ онд сэргэж²⁰, нийт экспортын орлогын өсөлтийн 1.6 нэгж хувийг бий болголоо (Хүснэгт 4.1).

Хүснэгт 4.1 Уул уурхайн экспорт нийт экспортын өсөлтийг тэтгэж байна

сая ам.доллар	2022 IV	2023 IV	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт экспорт	3,621	3,888	7.4	7.4
Чулуун нүүрс	1,989	2,346	17.9	9.9
Боловсруулаагүй нефть	101	94	-7.0	-0.2
Мах, махан бүтээгдэхүүн	43	99		1.6
Бусад самар	12	16	31.0	0.1
Жонш, лейцит, нефелинт	41	87		1.3
Мөнгөний хүдэр, баяжмал	40	38	-4.5	-0.1
Молебдиний хүдэр, баяжмал	26	29	9.4	0.1
Төмрийн хүдэр, баяжмал	100	121	21.7	0.6
Мөнгөжөөгүй алт	378	177	-53.1	-5.5
Ноолуур	70	72	3.2	0.1
Цайрын хүдэр, баяжмал	60	28	-52.4	-0.9
Зэсийн хүдэр, баяжмал	560	626	11.8	1.8
Бусад	202	155	-23.2	-1.3

Эх сурвалж: ГЕГ

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр **импортын жилийн өсөлт** 2023 оны эхний 3 улиралд саараад байсан бол IV улиралд эргэн эрчимжиж 6.3 хувьд хүрлээ. Үүнд суудлын автомашин, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, тавилга, хүнс зэрэг хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлт голлон нөлөөлж байна. Мөн нүүрсний экспорттой уялдан дизель түлш, хөрөнгө оруулалтын шинжтэй барааны импортын эрэлт өндөр хэвээр байна (Хүснэгт 4.2).

Хүснэгт 4.2 Импортын өсөлт эрчимжиж, IV улиралд 6.3 хувь байна


сая ам.доллар	2022 IV	2023 IV	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт импорт	2,348	2,497	6.3	6.3
Хэрэглээний бүтээгдэхүүн	658	769	16.9	4.7
Түргэн эдэлгээт	380	411	8.2	1.3
Удаан эдэлгээт	278	358	29.0	3.4
Суудлын автомашин	169	201	18.7	1.3
Хөрөнгө оруулалтын бүт.н	900	992	10.2	3.9
Нефтийн бүтээгдэхүүн	495	500	1.0	0.2
Дизель	289	309	7.0	0.9
Бусад шатахуун	207	191	-7.3	-0.6
Аж үйлдвэрлэлийн орц	291	226	-22.3	-2.8
Бусад	4.5	9.8		0.2

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк

²⁰ Гол худалдан авагч БНХАУ өмнөх жилийн эхний хагаст манай улсаас авах махны импортыг түр зогсоож байв.

Үйлчилгээний дансны алдагдал төдийлөн буурахгүй өндөр хэвээр байна. Үүнд тээвэр, боловсрол, бизнесийн үйлчилгээний зардал голчлон нөлөөлж байна (Зураг 4.4).


Зураг 4.4 Үйлчилгээний данс



Эх сурвалж: Монголбанк

Орлогын дансны алдагдал IV улиралд 680 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 163 сая ам.доллараар их байна (Зураг 4.5). Дотоодын аж ахуйн нэгжүүд болон Хөгжлийн банкны гадаад зээлийн хүүний төлбөр өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн нь нөлөөлжээ. Түүнчлэн Оюу толгойн зээлийн хүүний хуримтлагдсан дүн орлогын дансны алдагдлыг нэмэгдүүлж байна.

Зураг 4.5 Орлогын дансны алдагдал




Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны тэнцэл 2023 оны IV улиралд 1 тэрбум ам.долларын ашигтай байна. Оюу толгойн далд уурхайн бүтээн

байгуулалтын санхүүжилт, хувийн секторын гадаад зээлийн ашиглалт, нүүрсний компаниудын экспортын урьдчилгаа санхүүжилт өндөр байсан нь санхүүгийн дансны орох урсгалыг голлон бүрдүүллээ. Түүнчлэн тайлант хугацаанд МИК-ийн Бөртэ бондын \$225 сая ам.доллар, Хуралдай бондын \$223 сая ам.долларыг тус тус дахин санхүүжүүлсэн нь санхүүгийн дансны ашигт эерэгээр нөлөөлөв.

Зураг 4.6 Санхүүгийн данс 1 тэрбум ам.долларын ашигтай байв.



Эх сурвалж: Монголбанк

